



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/12

Чингис хот

Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ардчилсан шинэ үндсэн хуулийг батлалцсан Хэнтий аймгийн нэр бүхий депутатуудад 4.500.000 /дөрвөн сая таван зуун мянган/ төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламж олгох зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөх боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-г, гүйцэтгэлийг зохион байгуулж хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010050

Депутатуудын нэрс

№	Овог нэр	Олгосон мөнгөн дүн	Нийт
1	Наваанмөнхийн Дэрийлаа	300.000	4.500.000
2	Лувсангийн Хээшиг	300.000	
3	Батмөнхийн Лигдэн	300.000	
4	Чойжавын Тэрбиш	300.000	
5	Цэрэндоржийн Ганбаяр	300.000	
6	Шагдарсүрэнгийн Иш-Цэрэн	300.000	
7	Ламжавын Баатарсүрэн	300.000	
8	Цэвэгдоржийн Даваажид	300.000	
9	Чимэддоржийн Баярсайхан	300.000	
10	Наваансамдангийн Ганбямба	300.000	
11	Сандуйн Ганболд	300.000	
12	Жаргалын Оросоо	300.000	
13	Найдангийн Төмөртоогоо	300.000	
14	Хоохорын Бадамсүрэн	300.000	
15	Пэрэнлэйн Ганзориг	300.000	